



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 197

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалт, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолын 3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Болзол батлах тухай" 87,88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/66 дугаар захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хошой аварга малчин болон аварга малчин, аварга саальчин, аварга хадланч, аварга тариаланч, алдарт уяач нарт хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 17,105,000 (арван долоон сая нэг зуун таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
01 дүгээр сарын 26 -ны өдрийн 7/92 дугаар
захирамжийн хавсралт

ХӨРӨНГИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл /эх бэлтгэл бичвэр/	270	40,000	10,800,000
2	Үдийн цай /кофе, печень, нэг удаагийн аяга/	500	4000	2,000,000
3	Тууз	205	21,000	4,305,000
НИЙТ				17,105,000

оОо

